



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 57

Хэрлэн сум

Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /55/ авсан Арбазнайн Алимааг сумын Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч А.Алимааг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг ажлын 14 өдрийн дотор албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын дарга /Л.Наранбат/-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын даргад хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Эрдэнэжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР